

# Виржиниагийн "Согтууруулах ундаа ба замын хөдөлгөөний аюулгүй байдал" хөтөлбөр (VASAP) Асаалтын систем блоклох гэрээ

Асаалтын систем блоклох төхөөрөмжийг суурилуулж буй "Согтууруулах ундаа ба замын хөдөлгөөний аюулгүй байдлын хөтөлбөр" (ASAP)-ын үйлчлүүлэгчид энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар дор заасан нөхцөл бүрийг бүрэн хэмжээнд ойлгож, аливаа асуудалгүйгээр дагаж мөрдөх ёстой гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа болно. Дагаж мөрдөөгүй тохиолдолд асаалтын систем блоклох шаардлагын хугацааг сунгах, үл мөрдсөн үндэслэлээр хэргийг шүүх рүү буцаах, ASAP-ын зүгээс хөндлөнгөөс оролцох оролцоог эрчимжүүлэх зэрэгт хүргэж болзошгүй.

1. Шүүхээс өөрөөр шийдвэрлээгүй бол согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон нь тогтоогдсон анхны тохиолдолд ASAP-ын үйлчлүүлэгчид өөрсдийн ажиллуулдаг тээврийн хэрэгсэлд асаалтын систем блоклох төхөөрөмжийг суурилуулах ёстой. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон нь тогтоогдсон хоёрдахь ба дараа дараагийн тохиолдолд ASAP-ын үйлчлүүлэгчид өөрсдийн ажиллуулдаг ба тэдгээрийн нэр дээр бүхэлд нь эсвэл хэсэгчилсэн байдлаар бүртгэлтэй бүх тээврийн хэрэгсэлд асаалтын систем блоклох төхөөрөмжийг суурилуулах ёстой.
2. Хэрэв асаалтын систем блоклох төхөөрөмжийг суурилуулах шийдвэр хүчин төгөлдөр үйлчилж байх хугацаанд ASAP-ын үйлчлүүлэгчид шинэ тээврийн хэрэгслийг өөрсдийн нэр дээр бүртгүүлвэл энэ тухайгаа ASAP-т ажлын 24 цагийн дотор мэдэгдэх ёстой. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон хоёрдахь ба дараа дараагийн тохиолдолд, мөн анхны тохиолдол бөгөөд үйлчлүүлэгч тухайн тээврийн хэрэгслийг жолоодохоор төлөвлөж байгаа бол шинэ тээврийн хэрэгслийг өөрийн нэр дээр бүртгүүлсэн эсвэл эрхийг нь шилжүүлж авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор уг машинд асаалтын систем блоклох төхөөрөмжийг суурилуулсан байх ёстой.
3. Өөрийн өмчийн бус тээврийн хэрэгсэлд асаалтын систем блоклох төхөөрөмжийг суурилуулж буй ASAP-ын үйлчлүүлэгчид суурилуултын үед "VASAP Асаалтын систем блоклох төхөөрөмж суурилуулах зөвшөөрлийн хуудас" (VASAP Ignition Interlock Consent to Install Form)-г бөглөж, блоклох төхөөрөмжийн техникчид өгөх ёстой. Эзэмшигч нь уг хуудсанд гарын үсэг зурж, нотариатаар баталгаажуулах эсвэл эзэмшигч өөрөө техникчийг гэрч болгон дэргэд нь гарын үсэг зурсан байх ёстой.
4. Блоклох төхөөрөмжийг "DC266 Асаалтын систем блоклох төхөөрөмж суурилуулах захирамж" (DC266 Ignition Interlock Order Form)-ийн хуудсанд заасан хүчинтэй өдрөөс хойш 30 хоногийн дотор суурилуулах ёстой бөгөөд Virginia Code 18.2-270.1-д заасны дагуу блоклох төхөөрөмжийг дор хаяж 30 хоног тутамд шалгаж, тохируулж байх ёстой.
5. Шүүхийн шийдвэрээр асаалтын систем блоклох төхөөрөмж суурилуулах шаардлагыг биелүүлж буй ASAP-ийн үйлчлүүлэгчид Тээврийн хэрэгслийн яамнаас (DMV) лицензтэй холбогдуулан гаргасан бүх шийдвэрийг дагаж, блоклох төхөөрөмж суурилуулах зөвшөөрлийг авсан байх ёстой. Хүчин төгөлдөр үйлчилж буй зөвшөөрөл цаасан хэлбэрээр дагалдаагүй тохиолдолд хязгаарлагдмал зөвшөөрлийн захирамжийн (DC-265) баримт нь тухайн захирамжид заасан эхлэх огнооноос хойш 60 хоногийн турш хүчин төгөлдөр байна.
6. DMV-аас гаргасан блоклох төхөөрөмж суурилуулах шаардлагыг биелүүлж буй ASAP-ын үйлчлүүлэгчдийн хувьд DMV-аас зөвшөөрлийг бичгэн хэлбэрээр авах хүртэл блоклох төхөөрөмж суурилуулсан хугацаанд кредит олгохгүй.
7. ASAP-ын үйлчлүүлэгчид шалгалтанд тэнцээгүй эсвэл алгассан тохиолдолд 15 минутын дотор согтуурлын зэрэг тодорхойлох төхөөрөмж рүү хоёрдахь удаагаа үлээж, шалгуулах ёстой. Ингэснээр ASAP нь анхны удаа үлээж, тэнцээгүй дээж нь цусан дахь спиртээс үүдэлтэй юу эсвэл аманд үлдсэн спиртийн үлдэгдлээс үүдэлтэй юу гэдгийг илүү хялбар тодорхойлох боломжтой байна. Тэнцээгүй тохиолдолд дахин шалгуулахгүй бол үүнийг асаалтын системийг блоклох үндэслэл бүхий зөрчил гэж үзнэ. Үүн дээр нэмж хэлэхэд үлээх төхөөрөмж рүү үлээж шалгуулахад тухайн дээжээр илэрсэн

# Виржиниагийн "Согтууруулах ундаа ба замын хөдөлгөөний аюулгүй байдал" хөтөлбөр (VASAP) Асаалтын систем блоклох гэрээ

цусан дахь спиртийн агууламж нь дээд хязгаар буюу .020% ба түүнээс дээш байх эсвэл аливаа алгассан шалгалт нь 15 минутын дотор .000% болж, цэвэр болсон байх ёстой.

8. Камераар авсан гэрэл зургууд өөрөөр нотлосон байхаас бусад тохиолдолд ASAP үйлчлүүлэгчид блоклох төхөөрөмж дээрх бүх үйл хөдөлгөөнийг дангаараа хариуцна. Төхөөрөмжид амьсгалын дээж өгч буй хүн блоклох төхөөрөмжийн камерын гэрэл зураг дээр сайн харагдахгүй байх, танигдах боломжгүй байх бүх тохиолдлыг асаалтын системийг блоклох үндэслэл бүхий зөрчил гэж үзнэ.
9. ASAP-ын үйлчлүүлэгчид тээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засварын цехээс тухайн тээврийн хэрэгсэлд хийсэн үйлчилгээний төрөл, тээврийн хэрэгслийг засварын цехэд хүлээн авч, эзэнд нь буцааж хүлээлгэн өгсөн өдрийг баримтжуулж олгосон албан баримт бичгийг хүлээн авсан даруйдаа ASAP-т хүлээлгэн өгөх ёстой.
10. ASAP-ын үйлчлүүлэгчид эцсийн тохируулгыг блоклох төхөөрөмж суурилуулах шаардлагыг тавьсан өдөр эсвэл дараа нь хийж дуусгах шаардлагатай.
11. VASAP-ын асуудал хариуцсан комиссоос зөвшөөрсөн байхаас бусад тохиолдолд ASAP-ын үйлчлүүлэгчид блоклох төхөөрөмжийг нэгэнт суурилуулсны дараагаар ханган нийлүүлэгчийг өөрчлөх эрхгүй болно.
12. DMV-ны захиргааны хэргүүдтэй холбогдуулан ASAP-ын блоклох төхөөрөмж хянах төлбөр нь сарын 50 ам. доллар болно. Төлбөрийг бүрэн гүйцэд төлөөгүй тохиолдолд ASAP нь DMV-аас гаргасан блоклох төхөөрөмж суурилуулах шаардлагыг амжилттай хангаж, биелүүлэхгүй.
13. ASAP-ын үйлчлүүлэгчид асаалтын систем блоклох төхөөрөмжийн талаарх видеог <http://vasap.virginia.gov> хаягаар орж үзэж болно.

**Эдгээр нөхцөл, болзол нь шүүх болон DMV-аас гаргасан асаалтын систем блоклох төхөөрөмжийг суурилуулах тухай бүх шийдвэрийг амжилттай биелүүлэх хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ. Асаалтын систем блоклох төхөөрөмжийг суурилуулах тухай бүх шийдвэрийг дагаж мөрдөөгүй тохиолдолд хэргийг шүүх рүү буцаах ба/эсвэл ASAP асаалтын систем блоклох хөтөлбөр цуцлагдахад хүргэж болзошгүй гэдгийг би ухамсарлан ойлгож байна. Доор гарын үсгээ зурснаар уг баримт бичгийн нэг хувийг хүлээн авсан бөгөөд түүнд дурдсан бүх нөхцөлийг ойлгож байгаагаа би хүлээн зөвшөөрч байна.**

---

Үйлчлүүлэгчийн нэр, дармалаар

---

Үйлчлүүлэгчийн гарын үсэг

---

Огноо